



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2007 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх  
этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл  
авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт  
бичгийн жагсаалт”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл болон 14.2.15 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчилж ажиллахыг Даатгалын газар (С.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ  
ШААРДЛАГА, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ  
ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэнэ) урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, баримт бичгийн бүрдүүлэлттэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Урт хугацааны даатгал гэдэгт даатгагч даатгуулагч нар харилцан гэрээний дагуу тохиролцож, даатгуулагч нас барахад эсвэл тодорхой цаг хугацааны эцэст даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөлөөр хангаж буй хүний амьдралыг даатгах үйл ажиллагааг.

**Хоёр. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага**

2.1. Монгол Улсын Компанийн тухай болон Даатгалын тухай хуулийн дагуу урт хугацааны даатгал эрхлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компани байх.

2.2. Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, өргөдөл гаргагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь дор дурдсанаас бусад этгээд байх:

2.2.1. Уг өргөдлийг гаргахаас өмнөх 2 жилийн хугацаанд аливаа шалтгаанаар дампуурсан, татан буугдсан компанийн удирдлага, санхүүгийн ажилтан, ТУЗ-ийн дарга, гишүүн байсан эсхүл түүний 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг байсан;

2.2.2. Хорооноос баталсан "Даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах журам"-д заасан аливаа шийтгэл, санхүүгийн зах зээл дэх хууль бус үйлдлийн улмаас эрүүгийн хариуцлагыг сүүлийн 3 жилийн хугацаанд хүлээсэн буюу хүлээж дууссан;

2.2.3. Урт хугацааны буюу амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхэлдэггүй гадаадын компани.

2.3. Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтын дагуу 1 тэрбум төгрөгийн дүрмийн санг бүрэн бүрдүүлсэн байх, дүрмийн сан нь адил хэмжээтэй нэрлэсэн үнэ бүхий хувьцаанд хуваагддаг байх.

2.4. Даатгалын тухай хуулийн 14.2.3 дахь заалтын дагуу даатгагчийн алдагдлаас хамгаалах санг 200.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэйгээр байгуулсан байх.

2.5. Өргөдөл гаргагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь даатгалын хууль тогтоомж, Хорооноос баталж гаргасан дүрэм журмыг сайтар судалсан байх, компанийн чадварлаг гүйцэтгэх удирдлага, даатгалын боловсон хүчнээр хангагдсан байх, даатгалын актуарчтай байх.

2.6. Хувь нийлүүлэгчид болон компанийн удирдах ажилтнууд нь Хорооноос баталсан "Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар"-т дурдсан шаардлагыг хангасан байх.

2.7. Өргөдөл гаргагч даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авах хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрлийн материалыг бүрдүүлэх болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг зохион байгуулах өөрийн итгэмжит төлөөлөгчийг томилж ажиллуулах. Итгэмжит төлөөлөгч нь энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу маягт бөглөсөн байна.

### **Гурав. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримт**

3.1. Компани байгуулж, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1 дүгээр зүйл, Даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.1.1. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг энэ журмын 1 дүгээр хавсралт маягтын дагуу гаргана.

3.1.2. Компанийг нэгээс дээш үүсгэн байгуулагч нийлж үүсгэн байгуулж байгаа бол компани байгуулж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар, нэг үүсгэн байгуулагчтай бол компани үүсгэн байгуулах шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

3.1.3. Компанийн дүрмийг нотариатаар баталгаажуулан ирүүлэх бөгөөд компанийн дүрэмд дараах зүйлийг тусгана: Үүнд:

3.1.3.1. Компанийн тухай хуулийн 16.2-д заасан зүйл;

3.1.3.2. Дүрмийн сангийн хэмжээ;

3.1.3.3. Дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;

3.1.3.4. Удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

3.1.3.5. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон ашиг сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;

3.1.3.6. Хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн ажиллах журам, бүрэн эрх, үүрэг, хариуцлага;

3.1.3.7. Өөрийн хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааг зохицуулах хууль зүйн үндэслэл, хууль тогтоомжид заасан бусад асуудал;

3.1.3.8. Компани татан буулгах үндэслэл, компанийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас иргэд, үйлчлүүлэгчдэд учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.

3.1.4. Бизнес төлөвлөгөөг зөвлөмжийн\* дагуу 5–аас дээш жилээр боловсруулж ирүүлнэ.

3.1.5. Дүрмийн санд оруулж байгаа хөрөнгө нь мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон сэжиг бүхий байвал Хороо нэмэлт мэдээлэл шаардана.

3.1.6. Хорооноос баталсан "Урт хугацааны даатгалын хэлбэрийн жагсаалт"-д дурдсан даатгалын хэлбэрүүдээс сонгож даатгагч зөвшөөрөл авна. Цаашид даатгалын хэлбэрүүдийн хүрээнд даатгалын бүтээгдэхүүн гаргаж болох энэ тухай бүрд эрхлэхийг хүссэн даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр Хорооноос зөвшөөрөл авна. Ингэхдээ даатгалын бүтээгдэхүүний танилцуулга, нийтэд санал болгох даатгалын гэрээ ба баталгааны загвар, маягт болон бусад Хорооноос шаардах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ.

3.1.7. Даатгалын гэрээ болон баталгааны ерөнхий нөхцөл, загварыг санал болгож буй даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр гарган ирүүлнэ. Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд заасныг үндэслэн даатгалын гэрээг байгуулах бөгөөд даатгалын гэрээ болон баталгаанд дараах зүйлийг нэмж тусгана. Үүнд:

3.1.7.1 Даатгалын нөхөн олговор олгох, түүнийг шийдвэрлэх хугацаа;

3.1.7.2 Даатгалын гэрээ хүчин төгөлдөр бус болох нөхцөлүүд;

3.1.7.3 Нөхөн олговор олгох, олгохгүй байх нөхцөлүүд;

3.1.7.4 Даатгагч, даатгуулагчийн хүлээх нэмэгдэл үүрэг, хариуцлага, эрхийн талаар гэрээ байгуулагч талууд тусгайлан тохирч гэрээнд нэмж тусгаж болно;

3.1.7.5 Даатгалын тохиолдол болсоныг даатгагчид мэдэгдэх (хот хөдөөд) хугацаа;

3.1.7.6 Даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдтэй холбогдсон асуудал;

3.1.7.7 Маргааныг шийдвэрлэх.

3.1.8. Хорооны актуарын тооцооны мэргэжилтнээр хянагдсан хураамжийн хувь хэмжээний тооцоолол, үндэслэл.

3.1.9. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн хангах талаарх мэдээлэл.

3.1.10. Компанийн дүрмийн санд хувь нийлүүлэгч нарын оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолтууд, үүсгэн байгуулагчдын өр төлбөргүй талаархи холбогдох байгууллагуудын /татвар, өр барагдуулах алба/ албан ёсны тодорхойлолт.

3.1.11. Хууль тогтоомжид заасан дүрмийн сангийн доод хэмжээг тусгасан эхлэлтийн тайлан.

3.1.12. Үүсгэн байгуулагчид, хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүд тогтоосон маягтын\* дагуу тодорхойлолтыг гаргаж ирүүлнэ.

3.1.13. Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу томилогдсон захирал, салбарын удирдлага, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд болон боловсон хүчний тодорхойлолтыг маягтын\* дагуу гаргаж ирүүлнэ.

3.1.14. Компанийн үүсгэн байгуулагчид, хувь нийлүүлэгчид, эрх бүхий албан тушаалтны ял шийтгэлтэй эсэх талаархи Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

3.1.15. Техник тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны тодорхойлолтыг тогтоосон маягтын\* дагуу гаргаж ирүүлнэ.

### **Дөрөв. Бусад**

4.1. Энэ журмаар заагаагүй тусгай зөвшөөрлийн материалын бүрдүүлэлттэй холбоотой бусад асуудал болон бизнес төлөвлөгөөний зөвлөмж\*, маягтын\* загварыг Хорооны 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-д заасан бизнес төлөвлөгөө гаргах зөвлөмж\*, даатгагчийн бүрдүүлэх материал, тэдгээрийн маягтын\* нэгэн адил нөхцөлтэйгөөр гаргаж ирүүлнэ.

4.2. Хороо нь энэ журмын биелэлтэнд хяналт тавьж, газар дээр нь шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

“Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 1 дүгээр хавсралт

УРТ ХУГАЦААТ ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: .....  
Хаана: САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО-нд  
Засгийн газрын 4-р байр  
Бага тойруу-6,  
Улаанбаатар-46  
Монгол улс  
Хэнээс: .....

/Өргөдөл гаргагчийн овог нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг/  
.....

/Урт хугацаат даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр/  
Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчид хурал хийж, дор дурдсан үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

Даатгалын ангилал .....

Даатгалын хэлбэр 1.....

2.....

3.....

Ердийн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах хуулийн этгээд, үүсгэн байгуулагч, иргэд тус компанид хөрөнгө оруулахаар шийдвэрлэв.

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ /мянган төгрөгөөр/

Компанийн үүсгэн байгуулагч (үүсгэн байгуулагчид) нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Компанийн гүйцэтгэх удирдлагад (гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд) энэ журмын шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллах болно.

Үүнд:

№	Овог нэр	Одоогийн эрхэлж буй ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Эрхлэх албан тушаал

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Урт хугацаат даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-д нийцүүлэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Урт хугацаат даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойших хугацаанд Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

### ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

/...../ /...../

/гарын үсэг/ /овог нэр/

Хуулийн этгээд бол:

/тамга тэмдэг/

.....  
/хуулийн этгээдийн нэр/ /албан тушаал/

/...../ /...../

/гарын үсэг/

/овог нэр/

“Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2 дугаар хавсралт

**Итгэмжит төлөөлөгчийн анкет**

1. Овог нэр
2. Иргэний үнэмлэхийн дугаар
3. Регистрийн дугаар
2. Харилцах утас
3. Улаанбаатар хот дахь байнгын хаяг
4. Мэргэжил, боловсрол:  
1....  
2.....
5. Одоогийн эрхэлж буй ажил, албан тушаал:
6. Бусад

ГАРЫН ҮСЭГ-----

ОГНОО-----



